



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Улсын хэмжээнд 2015 онд ашиглах
эмнэлэг, сувиллын орны
дээд хязгаарыг батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 12 дугаар зүйлийн 12.1.3 дах заалтыг тус тус үндэслэн эмнэлэг, сувиллын орны зохицуулалтыг эрүүл мэндийн байгууллагын өмчийн хэлбэр харгалзахгүйгээр адил тэгш шийдвэрлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Улсын хэмжээнд 2015 онд ашиглах эмнэлэг, сувиллын орны дээд хязгаарыг нэгдүгээр, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн орны дээд хязгаарыг хоёрдугаар, бусад салбарын харьяа тусгай эмнэлгүүдийн орны дээд хязгаарыг гуравдугаар, орон нутагт ашиглах эмнэлэг, сувиллын орны дээд хязгаарыг дөрөвдүгээр, нийслэлд ашиглах эмнэлэг, сувиллын орны дээд хязгаарыг тавдугаар, эрүүл мэндийн яамны тусгай зөвшөөрөл бүхий хувийн өмчит эмнэлгүүдийн орны дээд хязгаарыг зургаадугаар, эрүүл мэндийн яамны тусгай зөвшөөрөл бүхий сувиллын орны дээд хязгаарыг долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Орны дээд хязгаарт орсон нэмэлт өөрчлөлт нь тухайн жилийн төсөвт тусгагдаагүй болон эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих сонгон шалгаруулалтад тэнцээгүй эрүүл мэндийн байгууллагын асуудлыг зохих хууль, журмын дагуу шийдвэрлэсний дүнд тус тушаалаар батлагдсан орны дээд хязгаарт багтаан зохицуулалт хийхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалаар тогтоосон 2015 онд ашиглах орны дээд хязгаарын хүрээнд хувийн өмчит эмнэлэг, сувиллын орны тоог тухайн байгууллагын тусгай зөвшөөрлийг үндэслэн эмнэлэг, сувилалуудад хуваарилан зохицуулахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

4. Орны дээд хязгаарын хүрээнд хуваарилсан орны тоог эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, түүний хавсралтад тусгах ажлыг 2015 оны 02 дугаар сард багтаан зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Эрдэнэчимэг), Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар (Р.Оюунханд)- т тус тус үүрэг даалгасугай.


080057

5. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (О.Баяр) –т үүрэг болгосугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Ганчимэг)-д даалгасугай.

7. Тус тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын “Эмнэлэг, рашаан сувиллын орны дээд хязгаарыг батлах тухай” 2013 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 24, “Эмнэлэг, сувиллын орны дээд хязгаарыг батлах тухай” 2014 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 51, “Эмнэлэг, сувиллын орны дээд хязгаарт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2014 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 394 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны .01 сарын .19 өдрийн
.15 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

УЛСЫН ХЭМЖЭЭНД 2015 ОНД АШИГЛАХ ЭМНЭЛЭГ,
СУВИЛЛЫН ОРНЫ ДЭЭД ХЯЗГААР

№	Эрүүл мэндийн байгууллага засаг захиргааны нэгж, төрлөөр	Бүгд ор	БОЭТ, аймгийн нэгдсэн эмнэлэг, сум дунд, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, сум, тосгоны эрүүл мэндийн төв, өвөрмөц үйлчилгээ бүхий эмнэлгүүд			Тусгай, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн ор бүхий төв, нийслэлийн харьяа төрийн өмчит эмнэлгүүд			Хувийн өмчит эрүүл мэндийн байгууллага	
			Бүгд	ЭМД	Төсөв	Бүгд	ЭМД	Төсөв	Эмнэлэг	Сувилал
1	Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн ор бүхий төв 2-р хавсралт	4187	0	0	0	4187	2528	1659	0	0
2	Тусгай эмнэлэг 3-р хавсралт	1201	0	0	0	1201	1027	174	0	0
3	Орон нутгийн эмнэлэг, сувилал 4-р хавсралт	10928	8489	4023	4466	0	0	0	1479	960
4	Нийслэлийн харьяа эмнэлэг, сувилал 5-р хавсралт	5795	0	0	0	2785	1776	1009	2500	510
5	Улсын хэмжээний үйлчилгээ үзүүлж буй хувийн өмчит эмнэлэг, сувилалууд 6,7-р хавсралт	4268	0	0	0	0	0	0	1763	2505
6	Улсын хэмжээний нийт орны тоо	26379	8489	4023	4466	8173	5331	2857	5742	3975

Эрүүл мэнд, спортын сайдын
 2015 оны 01 сарын 19 өдрийн
 75 дугаар тушаалын 2 дугаар
 хавсралт

ТӨВ ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ОР БҮХИЙ ТӨВҮҮДИЙН
 2015 ОНД АШИГЛАХ ОРНЫ ДЭЭД ХЯЗГААР

№	Эмнэлгийн нэр	Бүгд ор	Үүнээс:	
			ЭМД	Төсөв
1	Улсын I төв эмнэлэг	568	530	38
2	Улсын II төв эмнэлэг	195	185	10
3	Улсын III төв эмнэлэг	430	410	20
4	Хавдар судлалын үндэсний төв	275	50	225
5	Халдварт өвчин судлалын үндэсний төв	530	60	470
6	Гэмтэл согог судлалын үндэсний төв	412	400	12
7	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	450	0	450
8	Арьсны өвчин судлалын үндэсний төв	170	170	0
9	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	777	443	334
10	Уламжлалт анагаахын шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн корпораци	130	130	0
11	Уламжлалт анагаах ухааны элэг судлалын төв	100	100	0
12	Хүүхдийн төв сувилал	90	0	90
13	Геронтологийн үндэсний төв	60	50	10
	Бүгд	4187	2528	1659


Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 01 сарын 19 өдрийн
15...дугаар тушаалын 3 дугаар
хавсралт



БУСАД САЛБАРЫН ХАРЬЯА ТУСГАЙ ЭМНЭЛГҮҮДИЙН
2015 ОНД АШИГЛАХ ОРНЫ ДЭЭД ХЯЗГААР

№	Эрүүл мэндийн байгууллага засаг захиргааны нэгж, төрлөөр	Бүгд ор	ЭМД Сангаас санхүүжих орны тоо	Үүнээс:									
				Улаанбаатар төмөр харьяа замын эмнэлгүүд			ШШГЕГ-ын харьяа эмнэлгүүд			Батлан хамгаалах, хууль сахиулах албан хаагчдын нэгдсэн эмнэлэг			Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төв
				Бүгд	ЭМД	Төсөв	Бүгд	ЭМД	Төсөв	Бүгд	ЭМД	Төсөв	
1	Архангай			0			0			0			
2	Баян-Өлгий	10	10	0			0			10	10		
3	Баян-Хонгор	0		0			0			0			
4	Булган	5	5	0			5	5		0			
5	Говь-Алтай	5	5	0			0			5	5		
6	Говь-Сүмбэр	5	5	0			5	5		0			
7	Дархан-Уул	5	5	0			5	5		0			
8	Дорноговь	20	20	0			0			20	20		
9	Дорнод	30	30	0			0			30	30		
10	Дундговь	0	0	0			0			0			
11	Завхан	5	5	0			0			5	5		
12	Орхон	6	6	0			0			6	6		
13	Өвөрхангай	16	16	0			10	10		6	6		
14	Өмнөговь	15	15	0			0			15	15		
15	Сүхбаатар	10	10	0			0			10	10		

16	Сэлэнгэ	20	20	0			10	10		10	10		
17	Төв	109	34	0			100	25	75	9	9		
18	Увс	10	10	0			0			10	10		
19	Ховд	15	15	0			5	5		10	10		
20	Хөвсгөл	15	15	0			5	5		10	10		
21	Хэнтий	15	15	0			5	5		10	10		
22	Орон нутаг нийт	316	241	0	0	0	150	75	75	166	166	0	
23	Нийслэлд нийт	885	786	190	180	10	200	130	70	450	431	19	45
	Бүгд	1201	1027	190	180	10	350	205	145	616	597	19	45



Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 01 сарын 19 өдрийн
15 дугаар тушаалын 4 дүгээр
хавсралт

АЙМАГ, ОРОН НУТАГТ 2015 ОНД АШИГЛАХ ЭМНЭЛЭГ,
СУВИЛЛЫН ОРНЫ ДЭЭД ХЯЗГААР

№	Засаг захиргааны нэгжээр	Бүгд ор	БОЭТ, аймгийн нэгдсэн эмнэлэг, сум дунд, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, сум, тосгоны эрүүл мэндийн төв, өвөрмөц үйлчилгээ бүхий эмнэлгүүд			Хувийн өмчит эрүүл мэндийн байгууллага	
			Бүгд	ЭМД	Төсөв	эмнэлэг	сувилал
1	Архангай	531	411	163	248	100	20
2	Баян-Өлгий	671	536	240	296	135	
3	Баян-Хонгор	467	397	241	156	70	
4	Булган	352	265	108	157	67	20
5	Говь-Алтай	375	343	162	181	32	
6	Говь-Сүмбэр	105	105	80	25	0	
7	Дархан-Уул	674	429	264	165	245	
8	Дорноговь	448	348	180	168	40	60
9	Дорнод	428	371	183	188	57	0
10	Дундговь	327	200	124	76	27	100
11	Завхан	443	403	164	239	40	0
12	Орхон	538	444	217	227	94	0
13	Өвөрхангай	684	604	258	346	80	0
14	Өмнөговь	438	403	193	210	35	0
15	Сүхбаатар	336	304	143	161	32	0
16	Сэлэнгэ	621	541	224	317	80	0
17	Төв	951	476	176	300	45	430
18	Увс	555	450	184	266	45	60
19	Ховд	525	455	270	185	70	0
20	Хөвсгөл	756	610	239	371	146	0
21	Хэнтий	703	394	210	184	39	270
	Төрийн өмчит байгууллагууд нийт	8489	8489	4023	4466	0	0
	Хувийн өмчит байгууллагууд нийт	2439	0	0	0	1461	960
	Бүгд	10928	8489	4023	4466	1479	960

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 01 сарын 19 өдрийн
15 дугаар тушаалын 5 дугаар
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ХАРЬЯА ЭМНЭЛЭГ, СУВИЛЛЫН
2015 ОНД АШИГЛАХ ОРНЫ ДЭЭД ХЯЗГААР

№	Эрүүл мэндийн байгууллага	Бүгд ор	ЭМДСангаас санхүүжих орны тоо	Төсвөөс санхүүжих орны тоо	Хувийн өмчит эрүүл мэндийн байгууллагууд	
					эмнэлэг	сувилал
1	Сонгино хайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг	165	160	5	0	0
2	Сонгино хайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв	208	200	8	0	0
3	Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг	180	170	10	0	0
4	Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв	90	86	4	0	0
5	Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлэг	305	295	10	0	0
6	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв	227	215	12	0	0
7	Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв	235	220	15	0	0
8	Багануур Эрүүл мэндийн төв	200	145	55	0	0
9	Налайх Эрүүл мэндийн төв	165	135	30	0	0
10	Багахангай Эрүүл мэндийн төв	20	0	20	0	0
11	Энэрэл эмнэлэг	100	20	80	0	0
12	Наркологийн төв	75	0	75	0	0
13	Тосгоны эрүүл мэндийн төвүүд	95	0	95	0	0
14	1-р амаржих газар	390	100	290	0	0
15	2-р амаржих газар	180	0	180	0	0
16	3-р амаржих газар	150	30	120	0	0
	Төрийн өмчит байгууллага, нийт	2785	1776	1009		
	Хувийн өмчит байгууллага, нийт	3010			2500	510
	Бүгд	5795	1776	1009	2500	510

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны .01. сарын .19 өдрийн
..15 дугаар тушаалын 6 дугаар
хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ХУВИЙН ӨМЧИТ
ЭМНЭЛГҮҮДИЙН 2015 ОНД АШИГЛАХ ОРНЫ ДЭЭД ХЯЗГААР

№	Эрүүл мэндийн байгууллагууд	Бүгд ор
1	АШУҮИС-ийн нэгдсэн эмнэлэг	40
2	Манба дацан	80
3	Ачит Арвис ХХК-ны "Ачит-Эх" эмнэлэг	20
4	Дархан Детект эмнэлэг	40
5	Суперпроб эмнэлэг	30
6	Аюурвэд эмнэлэг	45
7	Аюурвэд-Энх ХХК-ийн Су Джок эмнэлэг	40
8	Интерферон-Альфа эмнэлэг	40
9	Гранд мед төв эмнэлэг	100
10	Интермед төв эмнэлэг	90
11	УБ Сонгдо төв эмнэлэг	90
12	Топаза эмнэлэг	25
13	Гурван гал нэгдсэн эмнэлэг	100
14	Монгол Ньюндай эмнэлэг	20
15	Дунфан найрамдал эмнэлэг	50
16	Дархан галдан эмнэлэг	20
17	Хан наж эмнэлэг	25
18	Аллержи мед эмнэлэг	50
19	Эпимон эмнэлэг	30
20	Улаанбаатар мед нэгдсэн эмнэлэг	50
21	Универсаль мед	40
22	Мөнхийн үйлс-2	35
23	Баяр эмнэлэг	30
24	Интенсив каре эмнэлэг	30
25	Грийн хом хоспис	20
26	Ач тус хоспис	15
27	Найдвар хоспис	15
28	Монг-Эм эмнэлэг	40
29	"Рендэжиүтэй Очирваань" ХХК-ийн эмнэлэг	30
30	Элэг эмнэлэг	40
31	Болор мэлмий эмнэлэг	20
32	Наран мандал эмнэлэг	10
33	ЭМЖЖ эмнэлэг	33
34	Жана Наран ХХК-ийн эмнэлэг	40
35	АШУҮИС-ийн НАСС-ийн эмнэлэг	10
36	Вестмед ХХК-ийн Отгонтэнгэр эмнэлэг	15
37	Ангиолог эмнэлэг	15
38	Ачтан-Элит эмнэлэг	300
39	Нууц увидас рашаан	30
40	Монгол- Оросын хамтарсан хөрөнгө оруулалттай Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн гадаад мэргэжилтнүүдийн эмнэлэг	10
	Нийт орны тоо	1763

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны .0.1. сарын .1.9 өдрийн
.../5 дугаар тушаалын 7 дугаар
хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ
СУВИЛЛЫН 2015 ОНД АШИГЛАХ ОРНЫ ДЭЭД ХЯЗГААР

№	Сувиллууд	Бүгд ор
Нэг. Рашаан сувилал		
1	Архангай аймаг дахь "Хасу шивэрт"	120
2	Архангай аймаг дахь "Сувд"	30
3	Баян-Өлгий аймаг дахь "Ахсу"	80
4	Баянхонгор аймаг дахь "Шаргалжуут"	400
5	Говь-Алтай аймаг дахь "Бигэр"	100
6	Завхан аймаг дахь "Отгон тэнгэр"	50
7	Өвөрхангай аймаг дахь "Хужирт"	450
8	Өвөрхангай аймаг дахь "Хужирт-Элма"	70
9	Хөвсгөл аймаг дахь "Галт халуун ус"	100
10	Хэнтий аймаг дахь "Аварга тосон"	340
Хоёр. Сэргээн засах сувилал		
11	Баатар ван	70
12	Багануур ХХК-ний "Багануур" сувилал	60
13	Богд уул сувилал	60
14	Дархан уул аймаг дахь "Да-Оюут"	40
15	"Жи Эм Эн Ти" ХХК-ийн сувилал	15
16	Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа "Жаргалан" сувилал	30
17	Оргил рашаан сувилал	230
18	Орхон аймаг дахь "Эрдэнэт"	50
19	Увидаст чанар	30
20	Улаанбаатар төмөр замын "Булагтай"	60
21	Хүүхдийн "Жаргалан" сувилал	70
22	ЭМЖЖ сувилал	50
	Нийт орны тоо	2505